



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 35,000,000.00 (гучин таван сая) төгрөгийн балансын үнэ, 23,300,923.10 (хорин гурван сая гурван зуун мянга есөн зуун хорин гурван төгрөг арван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Тогтохсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системд”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГ ЛАЛТЫН ХЭЛТГИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000448
7-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн
43 дугаар тогтоолын хавсралт

"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "МОНГОЛРОСЦВЕТМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хьюндай Женесис, 52-66 УНА, КМНГЛ41DFU042271	2015/2015	35,000,000.00	23,300,923.10	11,699,076.90
НИЙТ ДҮН			35,000,000.00 (гучин таван сая)	23,300,923.10 (хорин гурван сая гурван зуун мянга есөн зуун хорин гурван төгрөг арван мөнгө)	11,699,076.90 (арван нэгэн сая зургаан зуун ерэн есөн мянга далан зургаан төгрөг ерэн мөнгө)